

Цуврал 1. Амманы сэдэргэнэ буюу Бор элгэнэ



Зураг 1. Амманы сэдэргэний ерөнхий төрх

Мал бэлчээрлэлт нэмэгдэхэд тэжээлийн сайн чанартай болон зонхилон ургадаг үндсэн ургамлууд багасаад зогсохгүй ургамал ургах орчныг доройтуулдаг учир түүнд дасан зохицсон ургамлууд шалгарах гол нөлөө болдог¹. Эдгээр ургамлын нэг нь Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammanii* Desr) юм.

Иш дэвсмэл юмуу өндиймөл, 2-10 см, навчис нэг адил, өтгөн налархай, мөнгөлөг үсэрхэг шугаман юмуу шугамархуу юлдэн 1-4 мм өргөн, шаантган суурьтай, суумал. Цэцэг мөчрийн үзүүрт ганц нэгээрээ, дэлбэ 9-15 мм урт, цагаан юмуу цайвар ягаан байдаг.

Ойт хээр, хээр, говийн бүсэд хайргат ба чулуурхаг хажуу, элсэрхэг юмуу хайргат хээржүү цөл, элдэв өвст хээржүү хажуу эргийн хужирлаг нуга, хайрганд ургана². Хуурайсаг, үндэсний салмайт, олон наст өвслөг ургамал.

Бог мал зун сайн, намар дунд зэрэг иддэг³. Монголын уламжлалт эмнэлэгт газар дээрх хэсгийг судасны хатуурал, халуурал, тэмбүү, уушгины сүрьеэ зэрэг өвчнийг анагаах эмийн найрлагад оруулан хэрэглэдэг байжээ⁴.

Амманы сэдэргэнэ вегетативаар нөхөн ургахдаа сайн бөгөөд замын дагуу зурваслаж юмуу худаг, суурин газрын ойролцоох доройтсон газар, дэрсний зах зэрэг талхлагдаж эвдэрсэн хөрстэй газар ургадаг. Дунд талхлагдсан бэлчээрт энэ зүйлийн оролцоо нэмэгдэж эхэлдэг хэмээн судлаачид тогтоожээ¹.

Ургамлан нөмрөгийн өөрчлөлтөөр газрын доройтлыг үнэлэх чиглэлээр хийсэн бидний судалгааны явцад мал бэлчээрлэлтийн нөлөөнд өртөж хүчтэй доройтсон нутагт дээрх

¹ Чогний, О., 2001. Монголын ойт хээр, хээрийн бүсийн нүүдлээр ашиглагдсан бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх онцлог. УБ

² Грубов В. И. 2008. Монголын гуурст ургамал таних бичиг. УБ. х247

³ Өлзийхутаг Н. 1985. БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг. УБ. х400

⁴ Лигаа У., Даваасүрэн Б., Нинжил Н. 2005. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. х304

ургамал бүртгэгдэх бөгөөд зарим тохиолдолд бүлгэмдлийн зонхилогчийн оролцоотой болсон байна.

Доройтол хүчтэй илрэх Говьсүмбэр аймгийн Давайн талд тус ургамал $3.1 \pm 0.6\%$ буюу нийт бүрхцийн 30%-ийг эзэлж байна. Чулуусаг алаг өвс- Хазааргана- Крыловын Хялганат үндсэн бүлгэмдэл хялгана-хазааргана-сэдэргэнэт бүлгэмдлээр солигдож сэдэргэнэ зонхилогчийн оролцоотой болсон. Цоорхойн рашаанд Хялгана – Таанат бүлгэмдэл Улалж – хялгана – амманы сэдэргэнэт бүлгэмдлээр солигдож зонхилогч ургамал болох Амманы сэдэргэнэ $9 \pm 12\%$ буюу нийт бүрхцийн 41%-ийг бүрдүүлж байна. Мөн Өмнөговь аймгийн Булган сум, Арц Богдын хоолойд 2-60% бүрхэцтэй, зарим хэсэгт зонхилогчийн оролцоотой, харин Баруун Сайханы ойролцоо 2-3% бүрхэцтэй тохиолдож байв.



Зураг 2. Амманы сэдэргэнэ зонхилсон бүлгэмдэл

Харин харьцангуй чийглэг боловч хүчтэй доройтсон хялгана-хазаар-улалжит бүлгэмдэлд 2% бүрхэцтэй бөгөөд нийт бүрхцийн 3.5%-ийг (Төв аймгийн Баяндэлгэр сум), алаг өвс-хялганат хээрт 1% бүрхэцтэй буюу нийт бүрхцийн 2.3%-ийг (Сэлэнгэ аймгийн Хөтөл суманд) тус тус эзлэн тархсан байна.

Амманы сэдэргэнэ нь хуурай хээр болон говь, цөлийн бүсэд цөлжилт, газрын доройтлыг таних нэг үндсэн ургамал болох ба, харьцангуй чийглэг ойт хээр, уулын хээрт бага хувьтай, харин хот суурин газруудын ойролцоох доройтсон газруудад түгээмэл тохиолдоно.

Д.Отгонцэцэг

И-мэйл: otgondn@gmail.com

Газарзүй & Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны салбар